



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/320

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 онд Мал эмнэлэг үржлийн албаны түүхт 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Давааням (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)

Б.Мөнхбаатар (Сайхан Монгол ТВ-ийн захирал)

Э.Ням-Осор (Мал зүйч, үржүүлэгчдийн холбооны тэргүүн)


Х.Бат-Энх (Хувийн Мал эмнэлэг холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Э.Уянга (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Ойг тэмдэглэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах төлөвлөгөө баталж, шаардагдах тооцоо судалгаа гарган хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай..

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010304